

# Монголын орон нутгийн мэдээ

АЗИЙН БҮСИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗӨВЛӨЛИЙН ЗАХИАС БИЧИГ

## Их Эзэний Өргөөтэй болохын төлөө бэлтгэх нь

Азийн Бүсийн Ерөнхийлөгч Далын Ахлагч Антони Д.Перкинс

**А**зийн бүсийн Ерөнхийлөгчийн зөвлөлийнхнийг Азийн гэгээнтнүүдийн дунд аялан явах үед: “Манай улс эсвэл хот хэзээ Ариун Сүмтэй болох вэ?” гэсэн асуулыг олонтаа асуудаг. Их Эзэний Өргөөг гэсэн хайрыг тань бид сайшааж байна. Учир нь та нар Ерөнхийлөгч Томас С.Монсоны “Сүмийн гишүүнчлэлийн хамгийн чухал болоод эрхэм адислалууд нь Их Эзэний ариун сүмүүдэд бидний хүлээн авдаг тэдгээр адислалууд юм” хэмээх зөвлөгөөг ойлгодог.<sup>1</sup>

Би энэ асуултанд нэгэн хариулыг санал болгоё. Их Эзэн Өөрийн үйлчлэгч болох бошиглогчоор дамжуулан биднийг ариун сүмийн гэрээнүүд ба адислалуудад бэлэн болсныг илчлэх тэр үед бид танай улс эсвэл хотод ариун сүмтэй болох болно. Ариун сүм барих гол түлхүүр нь бидний хувийн болон хамтын бэлтгэл юм.

1838 онд Их Эзэн Иосеф Смитэд: “Тиймийн тул, миний гэгээнтнүүд хамтдаа цуглаж, тэд намайг шүтэн биширч болохын тулд, надад өргөө барихыг би та нарт зарлиглаж байна. Мөн энэ ажлын эхлэлийн суурь бэлтгэл ажил нь энэ дараагийн зун байг” гэж хэлсэн.<sup>2</sup>

Азийн бүс дэх ариун сүмийн тоог нэмэхийн тулд хүн тус бүр гурван “бэлтгэл ажлыг” хийж болно. Эдгээр нь бидний амьдралд асар их адислалыг авчирна гэдгийг би гэрчилж мөн амлаж байна.

### 1. Баптисм болон санваарынхаа гэрээнүүдийг сахь

Бидний хамгийн анхны бэлтгэл ажил бол баптисмын усанд орохдоо мөн Түүний санваарыг хүлээн авахдаа Есүс Христтэй хийсэн гэрээгээ сахих явдал. Анхныхаа гэрээг сахиснаар бид ариун сүмд орж, Бурхантай илүү үнэ цэнэтэй гэрээнүүдийг хийхэд бэлэн гэдгээ харуулдаг.

Ариун сүмүүд Тэнгэрлэг Эцэгийн авралын төлөвлөгөө хийгээд Есүс Христийн цагаатгагч золиослол дээр гол анхаарлаа төвлөрүүлдэг. Тиймээс бид долоо хоног бүр зохистойгоор

ариун ёслолоос хүртсэнээр ариун сүмд бэлтгэгддэг. Долоо хоног бүрийн ариун ёслолоор дамжуулан бид өөрсдийн дээр Христийн нэрийг авч, үргэлж Түүнийг санаж, мөн Түүний зарлигуудыг сахих баптисмынхаа гэрээг шинэчилдэг.<sup>3</sup>

Ариун Сүм бол Их Эзэний Их Сургууль мөн. Ням гарагуудад сайн мэдээний ангиудад мөн долоо хоногийн дундуур Семинар ба Институдад хамрагдан суралцсанаар бид бэлтгэдэг. Сайн мэдээний дагуу амьдрахыг хичээгчдийн хувьд, бид “мөнх амьдралын үгсэд хичээнгүйлэн анхаарал тавихдаа хянамгай байж”, “Бурханы амнаас урагш гарах үг бүрээр амьдрах ёстой”<sup>4</sup> хэмээх гэрээг сахидаг.

Ариун сүм бол бидний нас нөгчсөн өвөг дээдэстэй үйлчлэх газар мөн. Тиймээс бид Сүмийн дуудлагуудаараа дамжуулан амьд сэрүүн хөршүүддээ үйлчилснээр бэлтгэгддэг. Бид дуудлагаа эрхэмлэн биелүүлэх үед<sup>5</sup> “нэг нэгнийхээ ачааг . . . үүрэлцэх,” “гашуудах тэдний хамт гашуудах” мөн “тайтгарал хэрэгтэй тэднийг тайтгаруулах”<sup>6</sup> баптисмын гэрээгээ сахидаг.

Ариун сүмийн ёслолуудыг гүйцэтгэхэд нь туслах нэлээд хэдэн гадасны маш олон ажилчид ариун сүмд шаардлагатай байдаг. Тиймээс гэр бүл ба найз нөхдийгөө Есүс Христ ба Түүний сэргээгдсэн сайн мэдээнд урин дуудсанаар бид бэлтгэгддэг. Гишүүн номлогчийн хувьд, бид “ямар ч цагт мөн бүх зүйлд мөн өөрийн байж болох хаана ч гэсэн Бурханы гэрчлэгч болж, үхэлд хүртлээ зогсох”<sup>7</sup> баптисмынхаа гэрээг сахидаг.

Би та нарыг баптисм болон санваарынхаа гэрээг хэр сахиж байгаагаа шударгаар дүгнэж, илүү сайн сахихын тулд тодорхой үйлдэл хийхийг урьж байна. Үүнийг хийх аваас Ариун Сүнс та нарын байнгын хөтөч нь болох болно гэдгийг би амлаж байна. Гэрээнүүдээ хүндэтгэн,



Ахлагч Антони Д.Перкинс

сахиснаар та нар ариун сүмийн ёслолуудаар дамжуулан “мөнх бус амьдралд агуу ихээр адислагдаж, өргөмжлөлд ороход зохистой болох болно”<sup>8</sup> гэдгийг би мэднэ.

## 2. Аравны нэгээ бүрэн төл

Бидний хоёр дахь “бэлтгэл ажил” бол аравны нэгээ бүрэн хийгээд шударгаар төлөх явдал юм. Түүний бидэнд аль хэдийнээ өгчихөөд байгаа бүхний аравны нэгийг Их Эзэнд эргүүлэн өгснөөр Түүний сайн сайхан болон бэлгүүдэд талархаж байгаагаа бид илэрхийлж чадна. Бид мөн дэлхийн зүйлсийг хүсэх хүслээсээ илүү Түүний мөнхийн адислалуудыг хүсч байгаагаа үзүүлдэг.

Бидний үед, Аврагч Иосеф Смитэд ариун сүмд орохыг хүсэгчдэд аравны нэгээ төлөхийн чухлыг илчилсэн. Их Эзэн, “Болгоогтун, Сионы авралын төлөө надад өргөө баригдаж болохын тулд, энэ бол Их Эзэн, бибээр тэдний гараас шаардах аравны нэг хийгээд золиослол болой”<sup>9</sup> гэж хэлсэн. Ариун сүмийн эрхийн бичиг авах гэж байгаа болон авсан хүн бүр Бурханаар томилогдсон санваарын удирдагчийн өмнө үнэнч шударгаар аравны нэгээ бүрэн төлөгч гэдгээ батлах ёстой.

Магадгүй тэдний олонх нь өдөр тутмын хэрэгцээнд нь ч хүрэлцэх юмгүй байж болох ч, дэлхий дахины гишүүдийг Их Эзэн яагаад аравны нэгийг хуулийг сахихыг урамшуулдаг вэ? Ерөнхийлөгч Хинкли Филиппины Арлууд дахь Себуд, “хэдийгээр маш их ядуу зовлонг байдалд амьдарч байсан ч . . . хэрэв гишүүд сайн мэдээг хүлээн авч, үүгээр амьдран, өчүүхэн боловч аравны нэг ба мацгийн өргөлөө төлөх аваас, . . . тэд хувиандаа будаатай, нуруундаа хувцастай, толгой хорогдох байртай байх болно. Би үүнээс өөр шийдэл олж харахгүй байна”<sup>10</sup> гэж хэлсэн байдаг.

Би та нарыг аравны нэгээ бүрэн хийгээд шударгаар төлөхийг урьж байна. Бусад зардуудаа төлөхийн өмнө эхлээд Их Эзэндээ эргүүлэн төл. Би Есүсийн Нифайчуудад өгсөн Тэр “үүнийг хүлээн авах хангалттай зай байхгүй болтол би тэнгэрийн цонхнуудыг нээж, мөн та нарын дээр адислалыг цутгана”<sup>11</sup> хэмээх амлалтыг давтан хэлье.

## 3. Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахын тулд золиосол хий

Бидний гурав дахь “бэлтгэл ажил” бол ариун сүмийн ёслолуудыг хүлээн авч гэрээнүүдээ шинэчлэхийн төлөө золиослол хийх явдал юм.

Үүнийг хийснээр бид Их Эзэний өмнө эргэн очих чин хүсэлтэйгээ харуулдаг.

Есөн сарын өмнө, хайрт бошиглогч Томас С.Монсон: “Ариун сүмийн барилгыг барих хийгээд ариун сүмд ороход тодорхой хэмжээний золиослол хийгдсээр ирсэн. Бурханы ариун сүмүүдээс олдог өөрсдийн болон гэр бүлүүдийнхээ төлөөх адислалуудыг олж авахын тулд ихэд хөдөлмөрлөж, зовж зүдэрсэн хүмүүсийн тоо тоолж баршгүй их юм. . . . Яагаад ийм олон хүн ариун сүмийн адислалуудыг хүлээн авахын тулд тийм ихийг зориулахыг хүснэ вэ? Ариун сүмд хүлээн авсан авралын ёслолууд нь хэзээ нэгэн өдөр биднийг Тэнгэрлэг Эцэгтээ мөнхийн гэр бүлийн холбоонд эргэн очих, дээрээс ирэх адислалууд болон хүчний хишиг хүртсэн байх зөвшөөрлийг олгодог тул тэдний хийсэн золиослол болон хичээл зүтгэл бүр үнэ цэнэтэй гэдгийг ойлгодог”<sup>12</sup> хэмээн тунхагласан.

Ариун сүмийн ёслолуудыг хүлээн авахын тулд хийсэн золиослол тань та нарын нас болон амьдралын нөхцөл байдлуудаас шалтгаалан ялгаатай байх боловч золиослолын сүнс нь адил байх болно.

Залуу эрэгтэй болон сайн дурын залуу эмэгтэйчүүдийн хувьд ариун сүмийн золиослол нь бүрэн цагийн номлолд үйлчлэх явдал байх болно. Та нар сүнслэг, ёс суртахууны хувьд зохистой байж, номлолдоо чадлынхаа хэрээр хамгийн ихээр санхүүгийн хандив өргөхөөр өөрсдийгөө бэлтгэх болно. Бурханы бошиглогчоос номлолынхоо дуудлагыг хүлээн авсаны дараа, НБТ-д очихын өмнө эсвэл НБТ-д байхдаа та нар Их Эзэний Өргөөнд “тэнгэрийн хүчээр”<sup>13</sup> хишиг хүртсэн байх болно. Би та нарт Ерөнхийлөгч Монсоны 2010 оны 10 сарын Ерөнхий Чуулганаар хэлсэн “Залуу эрэгтэйчүүд ээ, би та нарыг номлогчоор үйлчлэхдээ бэлтгэхийг сануулж байна”<sup>14</sup> гэсэн урилгыг дахин хүргэе. Эзэний тулд хийгдсэн бүрэн цагийн номлолоос ирэх тоолохын аргагүй сүнслэг, материаллаг болон гэр бүлийн адислалуудыг би амлаж байна.

Гэрлэх бодолтой байгаа ганц бие залуу эрэгтэйчүүд хийгээд эмэгтэйчүүдийн хувьд та нарын ариун сүмийн золиослол нь гэрлэлттэй холбоотой буруу уламжлалын өмнө тавигдах ёстой юм шүү. Их хэмжээний мөнгө зарцуулан асар олон тооны гишүүн, гишүүн бус гэр бүлүүд, найз нөхдөө урин, үнэтэй бэлэг сэлт болсон тансаг хурим хийхийн оронд гэрлэлтээ батлуулах эсвэл орон нутгийн хуулийн дагуу даруухан ёслолыг

гүйцэтгэж болно. Тэгснээр та нар хадгалсан мөнгөтэй болж, гэрлэлтээ батлуулсан эсвэл энгийн иргэний бүртгэл хийлгэсэн даруйдаа ариун сүм уруу явах төлөвлөгөөгөө хийж болно. Та нар гэрлэлтийн төлөвлөгөөндөө энэ цаг үе хийгээд үүрд мөнхийн төлөөх ариун сүмийн холболтыг хойшлуулалгүй яг одоо хийгдэх зүйл болгож болох юм. Гэртээ эргэж ирсэнийхээ дараа та нар сүмийн байранд гэр бүл, найз нөхөдтэйгөө ариун сүмийн гэрлэлтээ тэмдэглэхээр энгийн зоог барьж болно. Би ганц бие гишүүд та нар-таа бошиглогч Спенсер В.Кимбаллын “Залуу хүмүүс ариун сүм уруу явж гэрлэхийн тулд . . . орон нутгийн гэрлэлтийн сүр жавхлантай, гял цал үзүүлбэрийг золиослох хүсэлтэй байх болно хэмээн бид найдаж байна”<sup>15</sup> гэсэн дараах урилгыг хүргэе. Зуун зууны хойч үеийнхэн тань энэ шийдвэр болон золиослолын тань төлөө та нарыг адислагдсан хэмээн дуудахаар босох болно гэдгийг би амлаж байна.<sup>16</sup>

Одоо ажиллаж байгаа Тайпей болон Хонг Конгийн ариун сүмийн ойролцоо амьдардаг, өөрсдийнхөө ариун сүмийн ёслолуудыг аль хэдийнээ хүлээн авсан гишүүдэд хайрт бошиглогчийнхоо “та нарын золиослол амьдралынхаа завгүй мөчүүдийг хойш нь тавиад ариун сүмдээ тогтмол очих юм”<sup>17</sup> хэмээн хэлсэн урилгыг дахин хэлье. Их Эзэний Өргөөний байнгын зочид байх аваас та нар болон та нарын гэр бүлийн дээр “нүгэл хилэнцийн нэгдэл . . . дийлэх хүчгүй байхыг” би амлаж байна.<sup>18</sup>

### Ариун сүмүүд сорилтууд хийгээд гэрчлэлүүдээр баригдсан

Азид ариун сүм барих нэмэлт газруудыг Их Эзэн Өөрийн бошиглогчоор илчлэх тэр өдөр ирнэ гэдгийг би мэдэж байна. Гэвч бид Ерөнхийлөгч Монсоны саяхны нэгэн гэрчлэлийг санах ёстой. Тэр, “Ариун сүмүүд нь чулуу шохойноос илүү зүйл юм. Тэд итгэл хийгээд мацаг барилтаар дүүргэгдсэн байдаг. Тэд сорилтууд хийгээд гэрчлэлүүдээр баригдсан. Тэд золиослол, үйлчлэлээр ариусгагдсан”<sup>19</sup> хэмээн хэлсэн.

Ариун сүм барих гол түлхүүр нь бидний хувийн болон хамтын бэлтгэл гэдгийг би гэрчилж байна. Бид баптисм болон санваарынхаа гэрээ нүүдийг сахиж, аравны нэгээ талархалтайгаар бүрэн, шударгаар төлж, ариун сүмийн ёслолуудыг хүлээн авах золиослол хийснээр ариун сүмтэй болох бэлтгэлийг хийдэг. Ийм бэлтгэл нь бидний Их Эзэн Есүс Христтэй хийх яриа болон

Тэнгэрлэг Эцэгийн агуу адислалуудыг хүлээн авах хүсэлд тусгалаа олдог. Есүс Христийн нэрээр, амен. ■

### ЭШЛЭЛҮҮД

1. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “The Holy Temple—A Beacon to the World,” *Лиахона*, 2011 оны 5 сар, 93.
2. С ба Г 115:8-9.
3. С ба Г 20:77; Мозая 18:10-г үз.
4. С ба Г 84:43-44.
5. С ба Г 84:33-ыг үз.
6. Мозая 18:8-9.
7. Мозая 18:9.
8. Гарын Авлага 2, 2.1.3.
9. С ба Г 97:12.
10. Ерөнхийлөгч Жеймс И.Фауст, “Opening the Windows of Heaven,” *Ensign*, 1998 оны 11 сар, 54.
11. 3 Нифай 24:10.
12. Ерөнхийлөгч Томас С.Монсон, *Лиахона*, 2011 оны 5-р сар, 92.
13. Ерөнхийлөгч Томас С.Монсон, “As We Meet Together Again,” *Лиахона*, 2010 оны 11 сар, 6.
14. С ба Г 95: 8; мөн С ба Г 43:15-16; 105:10-11.
15. Ерөнхийлөгч Спенсер В. Кимбалл, “Marriage—The Proper Way,” *New Era*, 1976 оны 2 сар, 6.
16. Сургаалт Үгс 31:28; Лук 1:48; С ба Г 107:54; Абрахам 2:10.
17. Ерөнхийлөгч Томас С. Монсон, *Лиахона*, 2011 оны 5-р сар, 92.
18. С ба Г 109:26; 24-26-г үз.
19. Ерөнхийлөгч Томас С. Монсон, *Лиахона*, 2011 оны 5-р сар, 92.

## ОРОН НУТАГТ БОЛЖ БУЙ ҮЙЛ ЯВДЛУУД

# Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс

*Ардчиллын шуурганы дараахан Монгол оронд маань Есүс Христийн сайн мэдээ ирсэн түүхэн хуудсууд эргэн өнгөрсөөр 2013 онд 20 жил болох гэж байна. Үүнтэй холбогдуулан 2012 жилийн турш Орон нутгийн мэдээ өөрийн буландaa “Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Түүхээс” гэсэн шинэ буланг нээж байна. Таалан соёрхоно уу.*

### Улаанбаатар Баруун Гадасны түүхч А.Тунгалаг

#### Монгол орон номлолын ажил нээгдэхэд бэлтгэгдсэн нь

Азид Сүмийг үндэслэн байгуулж, хөгжин дэгжихэд голлох үүрэг гүйцэтгэсэн Ахлагч Пол Хайер Монгол орныг номлолын ажилд нээх замыг бэлтгэхэд хувь нэмрээ оруулсан нэгэн бөгөөд энэ нь түүний

хувьд сүнслэг нөлөө бүхий түүхэн хэрэг байсан гэдэг. Пол Хайер 1951 онд Калифорнийн Беркелийн Их Сургуульд эрдмийн зэрэг хамгаалахаар сурч байх үеэс Монгол орныг сонирхож эхэлсэн ажээ. Пол Хайер нь “Буддын шарын шашин болон Монгол орныг Япончууд довтолсон нь” сэдвээр магистрын

зэрэг хамгаалсан бөгөөд сүүлийн 50 гаруй жил Монгол, Хятад, Япон, Тайвань зэрэг азийн орнуудын орчин үеийн түүхийг судалж, арвин бүтээл туурвисан байна.

Пол Хайер гэргий Карины хамт монгол найз нарынхаа хүрээг өргөтгөж, олон улсын симпозиум, эрдэм шинжилгээний хурлуудад оролцох, хүмүүнлэгийн салбар дахь төслүүд дээр Монголын Эмэгтэйчүүдийн Холбоотой хамтран ажиллах асуудлаар Монгол Улсад байнга ирж байжээ. 1992 оны наймдугаар сард Дэлхийн Монголч Эрдэмтдийн Чуулганд оролцохоор Улаанбаатарт ирэх үедээ Монголд ирэх цөөн тооны номлогчдын амьдрах нөхцлийг судалж байсан Ахлагч Монте Ж.Браутай уулзсан байна.

Энэ хожмын үйл хэрэгт зүрх сэтгэлээ зориулан ажилласан Ахлагч Монте Ж.Брау хоёр хүүгийнхээ хамт тэртээ 1984 онд монгол нутгаар аялах үедээ хөтөч нартаа сэргээгдсэн сайн мэдээ сонгохыг хүсч, залбирч байхдаа залбирлын хариу өгөөмрөөр ирэхийг мэдэрсэн биз ээ. Ахлагч Монте Ж.Брау 1988 онд Далын Нэгдүгээр Чуулгад дуудагдан, 1990 онд Азийн Бүсийн Ерөнхийлөгч Ахлагч Мерлин Либбертийн Нэгдүгээр зөвлөхөөр томилогдон, Их Эзэнд үйлчлэхдээ Азийн орнуудын сайн мэдээнд нэгдэх үйл ажиллагаануудад оролцох онцгой аз жавшаан түүнд мөн тохиосон ажээ.

Бригам Янгийн Их Сургуулийн Дэвид М.Кеннедийн нэрэмжит Олон Улс Судлалын Азийн Судалгааны дипломын дараах сургалтын удирдагчаар ажиллаж байсан профессор Пол Хайерын урилгаар Монгол

Улсын элчин сайд Гэндэнгийн Нямдоо 1991 оны 3-р сарын 20-ны өдөр “Монгол орон ардчиллын замаар” сэдэвт лекцийг Провод уншжээ.

Элчин сайд энэ айлчлалынхаа үеэр Юта Валлигийн Улсын Коллежийн Олон Улсын Судалгааны Төвийн захирал Малан Р.Жаксонтой биечлэн уулзаж, Юта Валлигийн Улсын Коллежтэй танилцаж, захирлын “Коммунизмаас ардчилалд шилжихэд нь Монгол Улсад ямар туслалцаа хэрэгтэй байна” хэмээх асуултанд “Манай залуучуудыг боловсролтой болгоход туслаач” гэж хариулж байжээ. Хожим нь Захирал Малан Р.Жаксон, “Орчин үеийн, олон ургальт ертөнцөд Монгол орон мөр зэрэгцэн хөгжих боломжинд Юта Валлигийн Улсын Коллеж жинтэй хувь нэмэр оруулсан нь тодорхой юм” хэмээн дурссан байдаг.

Элчин сайд Г.Нямдоо, Тэргүүн Зөвлөлийн урилгаар урьд өдөр нь Сүмийн Захиргааны байранд зочилж, Ерөнхийлөгч Гордон Б.Хинкли, Ерөнхийлөгч Томас С.Монсон болон Ахлагч Нийл Аш Максвелл, Ахлагч Пол Хайер, Хайерын хамтран ажиллагч С.Жигжид нартай уулзалт хийхдээ “Шинэ Монгол бол ардчилсан улс. Иймээс Сүмийн төлөөлөгчдийг баяртай хүлээн авах болно” гэж батлан хэлсэн байна. Ахлагч Пол Хайерд “Элчин сайдын энэ мэдэгдэл үнэхээр ач холбогдолтой юм” хэмээх бодол төржээ.

### **Сүм анх удаа албан ёсны хэлхээ холбоо тогтоосон нь**

1992 оны 3-р сарын 14-нд Колумб Дүүргийн Вашингтон дахь Монголын элчин сайд Даваагив Азийн

Бүсийн Ерөнхийлөгч Мерлин Либбертэд илгээсэн захидлыг сийрүүлбээс: “Танай байгууллагаас Монголд хүмүүнлэгийн үйлчилгээ, түүний дотор боловсролын хөгжилд тусламж үзүүлэх, Америкийн их сургуулиудад тэтгэлгээр суралцах, бизнесийн зөвлөлгөө өгөх, эрх зүй болон бусад салбарт үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон асуудлуудаар яриа хэлэлцээ хийхийн тулд миний бие Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Гадаад Хэргийн Яамны нэрийн өмнөөс Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Төлөөлөгчдийг Монголд айлчлахыг урьж байна” хэмээсэн Элчин сайдын албан ёсны урилга нь Монгол оронд очих Төлөөлөгчдөд визний зөвшөөрөл авах, Улаанбаатарт айлчлах төлөвлөгөө боловсруулах замыг Ахлагч Мерлин Либберт, Ахлагч Монте Ж.Брау нарт нээсэн байна.

Тэргүүн Зөвлөл болон Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгаас эрх олгогдсон, Ахлагч Либберт Ахлагч Брау хоёр 1992 оны 5 дугаар сард Монголын Засгийн Газар болон Боловсролын салбарын хүмүүст дипломат шугамаар тавьсан хүсэлтийн дагуу Монгол оронд зочлон, “хүмүүнлэгийн тусламжийн салбарт хийх зүйл асар их байгааг” мэдэрчээ. Тулгамдсан хэрэгцээг хангахын тулд баримжаагаар тооцоолсон эд материалын болоод хүний нөөцийн тусламж үзүүлэх саналыг Монголын албан тушаалтнууд хүлээн авсан байна.

Ахлагч Либберт, Ахлагч Брау хоёр “Шаардлагатай боловсрол эзэмшсэн таваас зургаан гэр бүлийн хосыг сонгож,

улмаар тэд Монгол хүмүүст ач тусаа үзүүлж, үр дүнд нь номлолын ажлыг эхлэх үүд хаалгыг нээж болох юм” гэсэн итгэл өвөрлөн, Монголоос буцсан байна. Угтаа бид монголчуудад хэрэгтэй болсон учир сайхь гэр бүлийн хосууд номлолын ажил хийж, сайн мэдээг зааж болно. Харин Монголчууд өөрсдийн хүсэлтээр сүмд элсч болно гэсэн санааг хэлэлцэж тохирсон байна. Улмаар Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөл зургаан гэр бүлийн хосыг Монголд дуудах саналыг Тэргүүн Зөвлөлд Ахлагч Нийл А.Максвеллын танилцуулсны дагуу тэр даруйд баталсан байна. 1992 оны 6 дугаар сард Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлөөс Сүмийн урьдчилан санал болгосон тусламжийг хэрэгжүүлэх болно гэдгийг Монгол дахь холбоотой байдаг хүмүүст мэдээлсэн байна.

### Монгол дахь ХУГС-ийн анхны ариун ёслолын цуглаан

Тэртээ 1992 оны 9-р сарын 20-ны өдөр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Монгол дахь салбарын анхны цуглаан болжээ. Тухайн үед салбар нь албан ёсны бүртгэлгүй байсан бөгөөд Азийн Бүсийн Ерөнхийлөгчийн Зөвлөлийн удирдлага дор ажиллаж, сайн мэдээг түгээхээр дуудагдсан анхдагчдын эхний гэр бүлийн номлогч хос Ахлагч Кеннет Бийзли болон Систер Донна Бийзли нар байлаа. 1992 оны 10 сараас 1993 оны 5 сар хүртэлх хугацаанд удаах таван гэр бүлийн номлогч хосууд Монголд ирцгээсэн байна. Анхны зургаан номлогчид их онцгой нөхцөл байдалд ажиллаж, монголын боловсролын

системд туслахаар мөн сайн мэдээг түгээхээр ирсэн юм. Боловсролынхоо үүрэг хариуцлагын үеэр сайн мэдээг номлох боломжгүй, өдөр бүр гурваас таван ангид хичээл заах, сэдвээ бэлтгэх, суралцагсдынхаа даалгаврыг шалгах, засах гэхчилэн чөлөөт цагаар хязгаарлагдмал байжээ. Гэвч Их Эзэн номлогчдынхоо нөхцөл байдлыг анхааран үзэж, Есүс Христийн тухай сурч мэдэх сонирхолтой хүмүүсийг номлогчид руу илгээж байлаа. Коммунист засаглал 70 гаруй жил ноёрхох үедээ шашныг хориглож байсан ч эдгээр залуу хүмүүсийн үнэнийг сурах хүсэл эрмэлзэлийг дарж чадаагүй нь сонирхолтой байсан гээд, “Миний хонин сүрэг дууг минь сонсдог. Би тэднийг мэддэг бөгөөд тэд Намайг дагадаг юм” хэмээсэн Иоханы 10-р бүлгийн 27-р шүлэг бидний санаанд орж ирж байлаа хэмээн дурьдсан байдаг.

Эдгээр *Анхдагч нар* Сүмийн суурийг тавьж, Есүс Христийн сайн мэдээ монгол оронд дэлгэрэн, Сүм үүсэн хөгжсөн түүх нь Христийн зарлигийг хэрэгжүүлэх оргилуун хүсэл эрмэлзэлийн тод жишээ байсныг Бригам Янгийн Их Сургуулийн профессор Стивен К.Харпер өөрийн өгүүлэлдээ бахдан бичсэн байдаг билээ.

Монгол Улс Сионы анхны гадастай болж, Хожмын үеийн гэгээнтэн 9000 гаруй ах эгч нар Гадас болон хоёр Дүүргийн 21 салбар нэгжид хамрагдан, өөрсдийн амьдрал болон гэр бүлдээ сайн мэдээнээс суралцан, итгэгчдийн тоо өсөн нэмэгдсээр байгаа нь Арванхоёр Төлөөлөгчийн Чуулгын Ахлагч Нийл А.Максвелл ахын 18 жилийн өмнөх бошиглол биелэгдсээр байгаагийн баталгаа юм. ■

## Монголд Үйлчилсэн Номлолын Ерөнхийлөгчид Хүрэлцэн Ирж Гишүүдтэй Уулзлаа

Орон нутгийн мэдээний редактор Н.Пүрэвсүрэн

**2011** оны 9-р сарын 11-ны өдөр Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн Токиогийн гудамжин дахь саарал байр гэгээнтнүүдийн баяр хөөр, хайрын нулимс, сэтгэл хөдлөлөөр дүүрэн байлаа. Учир нь Монгол дахь Номлолын ажлыг өөрсдийн цаг үеүдэд урагш хөтлөн өөрчлөх үүргүүдийг хүлээн, Бурханы дуудлагаар бидний дунд үйлчилсэн 1999–2002 оны Номлолын Ерөнхийлөгч Кларк, эхнэр Кларк эгчийн хамт, 2007–2010 оны Номлолын Ерөнхийлөгч Андерсен, эхнэр Андерсен эгчийн хамт эргэн монголдоо зочилж, гэгээнтэн бидний магнайг тенийлгэлээ. Монголд Есүс Христийн сайн мэдээ дэлгэрээд удаагүй, гурван салбартай мянга хүрэхгүй гишүүдтэй байх үед Номлолын ажлаа эхэлж байсан Ерөнхийлөгч Кларк хөдөө орон нутгуудад хэрхэн анхны салбаруудыг эхлүүлж, Есүс Христийн сайн мэдээг түгээх ажилдаа олон янзын инээдтэй бөгөөд гунигтай туршлагауудтай тулгарч байснаа бидэнтэй илэн далангүй хуваалцан, зөвхөн Бурханы хүч,



Ерөнхийлөгч Кларк сүмийн гишүүдийн хамт

гэгээнтнүүдийн итгэлээр өнөөгийн амжилтууд ирсээр байгааг гэрчиллээ. Ерөнхийлөгч Кларк, Кларк эгч нар өөрсдийн цаг завьг Бурхандаа үйлчлэхэд зориулж яваа гайхамшигтай хүмүүс бөгөөд одоо тэд долоо дох номлолдоо (2011 оны 12-р сард) гарсан байгаа. Ерөнхийлөгч Андерсен монголд анхны Гадас байгуулагдах үйлсэд гол нөлөөг үзүүлсэн хүн бөгөөд түүний санваар болон сүнслэг нөлөөллийн хүчээр монголоос бүрэн цагийн номлолд үйчлэх номлогчдын тоо 30-аас 200 боллоо өссөн юм.

Тэдний үлгэр жишээ үнэхээр гайхамшигтай бөгөөд тэдний үйчлэл агуу юм. Мөн тэд олон монголчуудын амьдралыг өөрчилсөн билээ. Бид та нартаа хайртай. ■



Ерөнхийлөгч Андерсен, Андерсен эгч

Б.ЭНХБОЛД

## Ерөнхий Чуулганаас Хүлээн Авсан Сүнслэг Удирдамжинд Гэгээнтнүүд Талархалтай Байна

**Ж**ил тутмын Ерөнхий Чуулган хожмын үеийн гэгээнтэн бид бүгдэд сүнслэг гэжээл болж, ирэх саруудын маань удирдамж, Тэнгэрлэг Эцэг Есүс Христ амьдыг гэрчлэх агуу цугларалт болдог билээ. Энэ удаа ч мөн дэлхийн өнцөг булан бүрт байгаа гэгээнтнүүд Есүс Христийн сайн мэдээнд дахин нэгэнтээ цугларан, Табернекийн найрал дуучдын хамт бүгдээр зогсон, Бурханаа магтан дуулахад зүрх сэтгэл маань хайраар дүүрч, Түүнийг гэрчлэх Ариун Сүнс болон тэнгэр элчүүд бидний дунд хөвөн хамтдаа дуулан магтах шиг болно. Бурханы арми ямар их хүчтэйг, хэрэв бид Есүс Христийн сайн мэдээний дагуу Түүний зарлигуудад дуулгавартай байж, зөвийг сонгож, зөвийг хийх аваас ямар ч хүч биднийг дийлэх хүчгүйг улам бүр мэдрэх шиг болно. Монгол дахь Есүс Христийн Хожмын Үеийн Гэгээнтнүүдийн Сүмийн гишүүд өөр өөрсдийн уулзалтын байрууддаа цугларан, 2011 оны 10-р сарын Ерөнхий Чуулганаа үзэн, амьд бошиглогч, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болон Далын гишүүдийн сүнслэг заавруудыг авлаа. Сонгино тойргийн гишүүн Агвааны Мөнх-Эрдэнэ эгч, “Энэ хоёр өдөр бид Ерөнхий Чуулганаа үзэж, Сүмийн удирдагчдынхаа зааврыг сонслоо. Би дэлхий дээр амьдарч байгаа амьд бошиглогчийнхоо үгсийг сонсож, асуултуудынхаа хариуг олохын төлөө эртнээс залбирсан. Ахлагч Баллардын хэлсэн үгсээс Сүмийнхээ нэрийг бүтэн хэлэх хэрэгтэйг,

Ерөнхийлөгч Монсон ахын ярианаас асар их сүнсийг мэдэрлээ” гэж байхад, Баянзүрх салбарын гишүүн Дугарын Оюунбилэг эгч, “Энэ чуулганаар яг өөрийнхөө хүсч байсан хариултыг авсан. Энэ нь хүмүүстэй найрсаг бай. Бурханы зарлиг тушаал өнөө үед ч гэсэн хэвээр, энэ хүнд хэцүү нийгэмд бас биелэгдэнэ гэдгийг суралцсан” гэв. Манай ахмад номлогч Линда Форд эгч, “Нийгмийн Халамжийн Чуулган дээр Ерөнхийлөгч Угдорфын хэлсэн үгсээс Тэнгэрлэг Эцэг надад хэчнээн их хайртайг дахин саналаа. Мөн Ахлагч Хэйлсын хэлсэн үгсээс бүх зүйлс Бурханы цаг хугацаанд тохиодгийг суралцлаа. Надад одоо үнэхээр тэвчээр маш их хэрэгтэй байна” хэмээн нулимс дуслуулан байж хуваалцлаа. Монголын Баруун Гадасны Нэгдүгээр зөвлөх Намхайгийн Адъяаболд ах маань, “Энэ удаагийн чуулган дээр миний харж, хүлээж, хүсч байсан зүйл маань хувийн болон сүмийн амьдрал дахь үйлчлэлдээ сүнслэг удирдамж авах байлаа. Скотт ахын ярианаас судраа илүү ихээр суралцаж, тунгаан бодож, бүр цээжилж байхыг



Баянзүрх байранд

Н.ПҮРЭВСҮГЭН



Хамтдаа Бурханаа магтан дуулсан нь



Гэрээний хүүхдүүд

суралцсан. Өглөө бүр 15 минут судруудаас уншиж, цээжилж байхыг хичээх болно. Үүнийг хийхийг би бас бусад гишүүдэд уриалж байна. Яагаад гэвэл би олон удаа сүмийн талаар ярих боломжийг хайж байсан мөртлөө, Христийн үгсийг эхлээд олж авах тухай тэр судрыг өөрийн амьдралдаа хэрэгжүүлэхэд дутмаг байжээ. Би үүнийг илүүтэй ойлгож, мэдэрлээ. Мөн Томпсон эгчийн ярианаас олон хүн гэм нүгэл үйлддэг ч гэм нүгэлтнүүдийг хайрлаж, харин гэм нүглийг хайрлахгүй байх тухай суралцсан. Клэйтон ахын ярианаас Перу улсад Бурханы адислал асар ихээр асгарч, олон зуун мянган гишүүд

олон зуун гадсууд бий болж байгааг сонсоод би монгол улсын ирээдүйг бас тийм олон гадас, гишүүдтэйгээр төсөөлж байлаа. Монсон ахын ярианаас шинэ Ариун сүмүүдийг зарлаж байгааг сонсоод ирээдүйд нэгэн өдөр Монгол бас ингэж зарлуулах болно гэж бодож байв. Пакер ахын ярианаас дайны үед хүмүүсийн амьдрал маш хэцүү байсан. Гэвч даруу, дуулгавартай, үнэнч байсны хариуд адислалуудыг олсон. Өнөөдөр ч гэсэн дайнтай байгаа, сатантай дайтаж байгаа гэдгийг сануулсан. Санваартны чуулган дээр Ерөнхийлөгч Угдорф заахдаа, Хуучин гэрээн дээр Сионыг байгуулж байгаа түүх гардаг. Сүнслэг байдал ба материаллаг байдал өв тэгш байх ёстой. Бидний дунд ядуусгүй байж, хэрхэн сүнслэг ба материаллаг зүйлс зэрэгцэн зэрэг хөгжих ёстойг хэлсэн. Үүнийг би амьдралдаа хэрэгжүүлэхийг хүсч байна. Бид бие даах чадвараа дээшлүүлж амьдралаа сайжруулах ёстой. Корниш ахын ярианаас, Амьдралд болохгүй гээд заачихсан зүйлийг зөрчих хэрэггүйг суралцлаа. Мөн Даллин Оакс ахын үгсээс, Есүс бидний төлөө юу хийсэн юм бэ гэдгийг сайн бодож судраас болон сүмийн удирдагч нараас зааврыг эрэлхийлж байх хэрэгтэйг суралцлаа. Энэ удаагийн чуулган онцгой сүнслэг байлаа. Урьд урьдынхаас илүү адислал бидний дээр асгарах болно” гэв.

Энэ хожмын өдрүүдэд, атаат дайсны хилэн буцалсан дэлхийд амьдарч бидний дунд урагш алхах, зөвийг сонгох зааврыг өгөгч амьд Бошиглогч, Арванхоёр Төлөөлөгчийн Чуулга болоод Далын гишүүд, Сүмийн удирдагчид байдаг нь ямар гайхамшигтай вэ? ■

## Дезерет Олон Улсын Энэрлийн Байгууллагын Үйл Ажиллагаанаас

### Нярайг амилуулах сургалт

Сүм байгуулагдсан цагаасаа эхлэн төрөл бүрийн хүмүүнлэгийн тусламжийг үзүүлж, олон янзын төслүүдийг хэрэгжүүлдэг ирсэн билээ. Тэдгээрийн нэг нь манай улсын Анагаах ухааны салбарт хэрэгжүүлдэг төслүүд юм. Эдгээр төслүүдийн шугамаар

эмнэлгийн тоног төхөөрөмж ба багаж хэрэгсэл хандивлах, эм тариа бусад шаардлагатай зүйлсээр хангахын зэрэгцээ эмч ба эмнэлгийн ажилтнуудыг сургах сургалтуудыг олон улсын хэмжээний нарийн мэргэжлийн эмч мэргэжилтэнүүд ирж явуулдаг. Үндэсний

статистикийн газрын гаргасан мэдээгээр энэ онд төрөлт буурсан байна. Оны эхний 8 сарын байдлаар улсын хэмжээнд амьд төрсөн хүүхдийн тоо 44739 байгаа нь өнгөрсөн жилийн мөн үеийнхээс 1561-ээр буюу 3.4 хувиар, амаржсан эх 44558 болж, 1597 эхээр буюу 3.5 хувиар буурчээ. 2011 оны 9 сарын 8 ба 9-ны өдрүүдэд УБ дахь ХҮГС-ийн Баянзүрх байрны цуглааны зааланд нийт 21 аймаг ба хот, дүүргүүдийн Төрөхийн нийт 104



*Деннис Хажс эмч, Стивен Гровер эмч, Лиз Ховелл эгч ба төгсөгч*



*Сургалтын манекен*

эх баригчид, эмч сувилагчид оролцсон “Нярайг амилуулах” сургалтыг АНУ-аас ирсэн нарийн мэргэжлийн эмч Деннис Хажс, эмч Стивен Гровер, ахлах сувилагч Лиз Ховелл нар явууллаа. Сургалтыг тайлбар лекцээр эхэлж, сонирхсон асуултуудад нь хариулан дараа нь бодит нярайн манекен дээр

**Төгсөгчдийн зураг**



*Дадлага хийж байгаа нь*

дадлага хийн, суралцаж байв. Мэндэлсэн даруйдаа амьсгалахгүй байгаа нярайд амьсгал оруулах өндөр хариуцлагатай ажил эх баригч нарын өмнө байдаг. Дөнгөж төрсөн нярайн хорвоод мэндэлснээ зарлан уйлан чарлах дуунаас илүү сайхан дуу хоолой хаана байх билээ. ДОУЭБ сургалтыг

зохион байгуулах, сургалтын материал, плакат болон ном, гарын авлага мөн оролцогсдын замын зардлыг гарган дэмжлээ. Бид монголын хүүхэд олон болж, эцэг эх, эмээ өвөөгөө баярлуулах торгон агшин олон байхад хувь нэмрээ оруулсандаа баяртай байна. Энэ бол Их Эзэний гар мөн. ■

